# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 30 өдөр Дугаар 252 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалт, тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчит зарим хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 11 нэрийн, 662,971,940.01 (зургаан зуун жаран хоёр сая есөн зуун далан нэгэн мянга есөн зуун дөчин төгрөг нэг мөнгө) төгрөгийн балансын үнэ, 471,699,305.13 (дөрвөн зуун далан нэгэн сая зургаан зуун ерэн есөн мянган гурван зуун таван төгрөг арван гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий тээврийн хэрэгслийг хавсралтад заасны дагуу төрийн өмчийн данс бүртгэлээс хасч орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хавсралтад заасан төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал хавсралтад заасан аймгуудын Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор тээврийн хэрэгслийг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Тээврийн хэрэгслийг хавсралтад заасан орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх, засаж сэлбэн ашиглах, үнийг шинэчлэн тогтоож данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Тээврийн хэрэгслийн төлбөр хураамжийг бүрэн төлж улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

132001475

15-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
252 дугаар тогтоолын хавсралт

# ТӨРИЙН ӨМИЙН ЗАРИМ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ДАНС БҮРТГЭЛЭЭС ХАСЧ, ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД БҮРТГЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| Д/д | Байгууллагын нэр | Тээврийн хэрэгслийн марк | Улсын дугаар | Арлын дугаар | Үйлдвэрлэсэн/Ашиглалтад орсон он | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) | Хүлээлгэн өгсөн аймгийн нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ | Тоёота Ланд крүйзер 100 | 29-39 ГСА | JTEHT05JX02101624 | 2006/2006 | 13,254,000.00 | 2,761,250.00 | 10,492,750.00 | Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын Засаг даргын тамгын газарт |
| 2 | "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК | Тоёота ланд крүйзер 100 | 15-51 УБЯ | JTECJ09J605513127 | 2007/2007 | 64,389,705.47 | 64,389,705.47 | - | Архангай аймгийн Цахир сумын Засаг даргын Тамгын газарт |
| 3 | "Таван толгой төмөр зам" ХХК | Тоёота Ланд крүйзер 76 | 43-30 УАВ | JTEEB71JX0F006204 | 2019/2019 | 106,745,454.54 | 45,323,070.05 | 61,422,384.49 | Дорнод аймгийн Цагдаагийн газар |
| 4 | "Засгийн газрын Автобааз" ТӨҮГ | Ниссан патрол Y-62 | 08-91 УНТ | JN1TESY61Z0574199 | 2016/2016 | 85,000,000.00 | 85,000,000.00 | - | Ховд аймгийн Манхан сумын Засаг даргын Тамгын газарт |
| 5 | "Засгийн газрын Автобааз" ТӨҮГ | Ниссан патрол Y-62 | 99-06 УНҮ | JN1TANY62Z0020134 | 2013/2014 | 30,000,000.00 | 26,250,000.00 | 3,750,000.00 | Хэнтий аймгийн Хэнтий-Ус ХХК |
| 6 | "Засгийн газрын Автобааз" ТӨҮГ | Тоёота Ланд крүйзер 200 | 04-41 УБУ | JTMHU09J704016577 | 2008/2010 | 159,000,000.00 | 94,074,999.91 | 64,925,000.09 | Ховд аймгийн Дуут сумын Засаг даргын Тамгын газарт |

| Д/д | Байгууллагын нэр | Тээврийн хэрэгслийн марк | Улсын дугаар | Арлын дугаар | Үйлдвэрлэсэн/Ашиглалтад орсон он | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) | Хүлээлгэн өгсөн аймгийн нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | "Засгийн газрын Автобааз" ТӨҮГ | Тоёота Ланд круйзер 200 | 77-72 УНЦ | JTMHV09J1D4119481 | 2013/2013 | 30,000,000.00 | 26,250,000.00 | 3,750,000.00 | Ховд аймгийн Дөргөн сумын Засаг даргын Тамгын газарт |
| 8 | "Засгийн газрын Автобааз" ТӨҮГ | Хьюндай экуйс /Hyundai equus/ | 14-42 УНҮ | KMHGH41CBCU045880 | 2011/2011 | 29,450,000.00 | 15,706,666.70 | 13,743,333.30 | Нийслэлийн гэрлэх ёслолын гэрлэх ордон |
| 9 | "Эрдэнэс Монгол" ХХК | Ниссан экстрайл | 18-99 УНТ | JN1JBNT32Z0004363 | 2015/2015 | 69,900,000.00 | 56,502,500.00 | 13,397,500.00 | Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын Тамгын газарт |
| 10 | "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК | Волксваген тигуан | 55-35 УНЭ | WVGZZZ5NZBW120559 | 2011/2011 | 50,232,780.00 | 50,232,780.00 | - | Хэнтий аймгийн Боловсролын газар |
| 11 | "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХХК | Ниссан патрол Y-62 | 19-84 УБА | JN1TANY62Z0030143 | 2016/2016 | 25,000,000.00 | 5,208,333.00 | 19,791,667.00 | Өвөрхангай аймгийн Хархорин сумын Засаг даргын Тамгын газарт |
| Нийт дүн | | | | | | 662,971,940.01<br>(зургаан зуун жаран хоёр сая есөн зуун далан нэгэн мянга есөн зуун дөчин төгрөг нэг мөнгө) | 471,699,305.13<br>(дөрвөн зуун далан нэгэн сая зургаан зуун ерэн есөн мянган гурван зуун таван төгрөг арван гурван мөнгө) | 191,272,634.88<br>(нэг зуун ерэн нэгэн сая хоёр зуун далан хоёр мянга зургаан зуун гучин дөрвөн төгрөг наян найман мөнгө) | |